

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон энэ онд хийгдсэн хяналт шинжилгээ үнэлгээний мөрөөр аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс 24 сумын төрийн албан хаагчдыг бодлогын баримт бичгийг боловсруулах, тайлагнах, төлөвлөх, төрийн албаны болон архив бичиг хэргийн стандартын сургалтууд болон харилцан туршлага солилцох, урлаг, спортын арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Энэхүү үйл ажиллагаанд аймаг, сумдын удирдлага, төрийн албан хаагчид идэвхи санаачлагатай оролцон сургалтыг хойд бүсийн 9 сумыг Асгат суманд, урд бүсийн 4 сумыг Шилүүстэй суманд, зүүн бүсийн 6 сумыг Тосонцэнгэл суманд тус тус зохион байгууллаа.

Сургалтанд нийт 19 сумын 360 гаруй төрийн албан хаагчид хамрагдан мэдлэг чадвараа дээшлүүлэн харилцан туршлага солилцлоо.

Сумдаас сургалтын үйл ажиллагаанд сум хамт олноороо идэвхи санаачлагатай оролцон тэргүүн байранд шалгарч шилжин явах цом, мөнгөн шагналаар Сонгино, Отгон, Тэлмэн сумдыг урамшууллаа. Цаашид энэхүү арга хэмжээ уламжлал болон зохион байгуулах зорилттой ажиллаж байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС